



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

Үйлдвэрчний эвлэлийн гудамж 37, 29 дүгээр хороо,
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18072

Утас: 7018 1208, 7018 1447, 7018 1206,

Цахим шуудан: info@ngs.gov.mn,

Цахим хуудас: www.ngs.gov.mn

2025. 12. 19 № *1/913*

танай _____-ны № _____-т

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС
БАЯЛГИЙН ЯАМАНД**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Үндэсний геологийн албаны 2025 онд хариуцан
хэрэгжүүлэхээр тусгагдсан хууль тогтоомж, тогтоол
шийдвэрийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг
хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт *2/* хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *[Signature]* Н.МӨНХБИЛЭГ



D;2025ажлууд,бичиг төлөвлөлт

182505 00908

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Байгууллага: Үндэсний геологийн алба

Д/д	Шийдвэрийн нэр, огноо	Зүйл заалтын дугаар	Зүйл, заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжээгүй шалтгаан	Хяналтаас хасах үндэслэл
1	2	3	4	5	6	7	8
Монгол Улсын хууль (зөвхөн эрх олгосон заалт)							
1	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011-02-02	19.1.9.	Төрийн захиргааны төв байгууллага жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тухай тайлан, Жендерийн үндэсний хороонд дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэх.	Жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн 2024 оны мэдээг ЖҮХ-ны мэргэжилтэнд 2025.01.03-ны өдөр мэйлээр хүргэгдсэн. 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Улсын их хурлын Хууль зүйн байнгын хороо, Жендерийн үндэсний хороо, Жендерийн үндэсний хорооны дэргэдэх “Бодлогын зөвлөл” хамтран зохион байгуулсан Жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого ач холбогдол, үр нөлөөг таниулах, оролцогч талуудыг нэг мөр ойлголт, зорилгод нэгтгэх, үйлдэлд уриалах, сайн туршлагыг түгээх, тус бодлогыг хэрэгжүүлэхэд олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхэд орших зорилготой хуралд оролцсон. 2025.05.22-23-нд зохион байгуулагдсан Жендерийн эрх тэгш	100%	-	-

				байдал ба уур амьсгалын өөрчлөлт" олон улсын бага хуралд оролцсон. Төрийн албаны зөвлөлөөс 2025 оны 05 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулсан "Бүсчилсэн хөгжил төрийн албаны манлайлал" сэдэвт Улаанбаатар бүсийн зөвлөгөөнд оролцсон. 2025 онд Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт "Төрийн ба төсөвт байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хүний нөөцийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх ..." гэж заасныг чиглэл болгон ажилссаны дүнд 2025 онд 04 дүгээр сар хүртэл албаны албан хаагчдын хүйсийн харьцаа 72:28 буюу эрэгтэй албан хаагчдын хувь 28 байсан бол өнөөдрийн байдлаар 65:35 буюу эрэгтэй албан хаагчдын эзлэх хувь 35 болж өссөн байна.			
2	Төрийн албаны тухай хууль 2017-12-07	55.3.	Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Үндэсний геологийн албаны даргын 2025 оны А/08 тушаалаар "Албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр", "Албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г баталсан ба хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна.	100%	-	-

				Тухайлбал: “Албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд: Монгол Улсын засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 238 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон ба тус тогтоолыг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Тогтоолын дагуу албан хаагчдын цалингийн хэмжээг ХНМУТ цахим системд бүртгэж, шинэчилсэн. Үндэсний геологийн албаны 2025 оны 1/76 дугаартай албан бичгээр зэрэг дэв олгох, зэрэг дэвийг ахиулах шаардлагыг хангасан 4 албан хаагчийн мэдээллийг Аж үйлдвэр эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 28-ны 08/1568 дугаартай албан бичгээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 05 дугаар сарын Б/09 дугаар тушаалаар Албаны 2 албан хаагчид зэрэг шинээр олгож, 2 албан хаагчид зэрэг дэвийг ахиулан олгосон. Холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн нас барсан 1 албан хаагчийн ар гэрт Үндэсний геологийн албаны даргын 2025 оны 05 дугаар сарын Б/35 дугаартай тушаалаар буцалтгүй тусламж олгосон.		
--	--	--	--	---	--	--

			Албан хаагчдын ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардалд өдөр бүр 3.0 мянган төгрөг, хоолны зардлыг өдөр бүр 32.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнгээр 2025 оны эхний хагас жилийн үр дүнгийн урамшуулал олгосон. Үндэсний геологийн албаны 1 албан хаагч, Үндэсний геологийн албаны дэргэдэх Монголын стратиграфийн комиссын 1 гишүүн, Улсын геологийн редакцын зөвлөлийн 1 гишүүнийг Төрийн дээд одон медаль, цол тэмдэгт нэр дэвшүүлж, холбогдох холбогдох материалыг бэлтгэн, Үндэсний геологийн албаны 2025 оны 06 дугаар сарын 1/367 дугаартай албан бичгээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн ба 2 нэр дэвшигч Төрийн дээд одон медалиар шагнуулсан. Албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хүрээнд 2025 онд 26 удаагийн сургалт зохион байгуулагдаж сургалтуудад давхардсан тоогоор 95 албан хаагч хамрагдсан байна. Тухайлбал: Ёс зүйн чиглэлийн 3 удаагийн сургалтад 35, Авлига, ашиг сонирхлоос ангид байх тухай 1 сургалтад 32, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх, чиглүүлэх болон төрийн албатай холбогдох 12			
--	--	--	--	--	--	--

				удаагийн сургалтад 15, санхүүгийн чиглэлийн 1 удаагийн сургалтад 1, ажил мэргэжлийн чиглэлийн 9 удаагийн сургалтад 12 албан хаагч тус тус хамрагдсан байна. 2025 оны албаны нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар “Ач интернешнл”, “Хавдар судлалын үндэсний төв”, “Оргил эмнэлэг” гэсэн 3 эмнэлгээс судалгаа авч, нийт албан хаагчдад танилцуулга бэлтгэн уулзалт хийсэн. Албан хаагчид дүрс оношилгооны “Оргил” эмнэлгийг сонгон 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 15-ны хооронд нийт албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. Урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 30 албан хаагч хамрагдсанаас 17 хүн Цээж хэвлийн тодосгогчтой Компьютер томограф, 12 хүн Тархины тодосгогчгүй MRI, 1 хүн Бага аарцгийн хөндийн тодосгогчтой Компьютер томограф оношилгоонд орсон.			
--	--	--	--	---	--	--	--

3	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай хууль, 2022-05-25	1.1, 1.2, 1.3	1.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай; 1.2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх; 1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах;	Байгууллагын 2025 оны худалдан авах ерөнхий төлөвлөгөөг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/108 дугаар тушаалаар батлуулсан. Үндэсний геологийн албаны 2026 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал, 2026-2028 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөөллийг боловсруулан, 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 1/306 тоот албан бичгээр Аж үйлдвэр, эрдэс баялгын яаманд хүргүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг Сангийн яамны хөрөнгө оруулалтын программ http://pimis.e-nation.mn/-д нэгтгэн байршуулсан. Албаны үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулсан.	100%	-	-
Хэсгийн дундаж: 100%							
Улсын Их Хурлын тогтоол							
1	Авлигатай тэмцэх үндэсний	2	Зорилго итгэлийг 2.Олон нийтийн хүлээсэн авлигаас	ҮГА-ны Авлигын эсрэг, шударга байдлыг дээшлүүлэх үйл	100%	-	-

	хөтөлбөр батлах тухай, 2023-06-30		ангид нийтийн албыг бэхжүүлнэ.	ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг тайлагнаж ажиллав. "Institute of Public Monitoring" судалгааны байгууллагатай хамтран Аж үйлдвэр эрдэс баялгийн салбарын авлигын эрсдэлийн судалгааг хийж гүйцэтгэв. Энэхүү судалгаа нь "Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын авлигын эрсдэлийн төсөөллийг судалгааг олон талын оролцоотойгоор боловсруулахад чиглэсэн бөгөөд нийт 18 хоногийн хугацаанд иргэн, хувийн хэвшил /хуулийн этгээд/, олон улсын байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл буюу төрийн бус байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж, бусад (хуульч, өмгөөлөгч, судлаач) гэсэн бүлгүүдийн төлөөлөл 550 оролцогчоос тухайн судалгааг авсан болно. Тус судалгаа нь аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт хамаарах голлох үйлдвэрлэл, эрдэс баялаг түүхий эдийн төрлөөс хамааран авлига үүсэх эрсдэл, тус салбарт холбогдох төрийн үйлчилгээ, албан хаагч, оролцогчдын үйл ажиллагаанд хаана авлигын эрсдэл үүсэх боломжтой гэж үзэж байгааг илрүүлэн эрсдэлийн түвшинг үнэлэх хэлбэрээр аж үйлдвэр, эрдэс баялгийн салбар дахь авлига, ашиг сонирхлын авлигын төсөөллийг боловсруулсан.			
--	-----------------------------------	--	--------------------------------	--	--	--	--

				Авлигатай тэмцэх газраас гаргасан бусад төрлийн хэлбэрээр сурталчилж байгаа Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн 14, 17, 18, 11, 21 дэх хэсгүүдтэй холбоотой сурталчилгааны брошюр мэдээллийг байгууллагын бүх албан хаагчид болон геологи судалгааны төсөл хэрэгжүүлж буй 14 аж ахуй нэгжид тараах, байгууллагын мэдээллийг самбарт байршуулах, дотоодын сүлжээнд авлигын эсрэг журмын шинэчлэл зэргийг байршуулж соён гэгээрүүлэх мэдээллийг олон нийтэд сурталчлах ажлыг гүйцэтгэв. Үндэсний геологийн албаны үйл ажиллагааг танилцуулж, авлигын хор хөнөөл, 110 тусгай дугаарыг сурталчилсан Анимэйшн 3D хэлбэртэй 1 минут 30 секундйн шторк бэлтгэж байгууллагын веб сайтад байршуулан ажиллав. АҮЭБЯам, Ашигт малтмал, газрын тосны газартай хамтран Авлига бол чимээгүй тахал нэртэй шторк бэлтгэж, байгууллагын веб сайтад байршуулсан. https://youtu.be/PqL2aAmTZbM НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Эрдэс баялгийн менежментэд шударга байдлыг бэхжүүлэхэд зориулсан Интегра тэтгэлэгт хөтөлбөрт Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны хамт Авлигын эрсдэлийг бууруулахад чиглэсэн			
--	--	--	--	--	--	--	--

				шинэлэг арга хэрэгсэл, механизм туршин нэвтрүүлэх төслийг боловсруулж, шалгаруулалтад тэнцсэн. Энэхүү тэтгэлгийн дүн 30 сая төгрөг бөгөөд төслийн хүрээнд авлигын эрсдэлийг тогтоох, бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Интерга төслийн хүрээнд ГБТА-ийн үйлчилгээг иргэдэд сурталчлахад зориулж гарын авлага брошюр хийж, хэвлүүлсэн. Иргэдэд тарааж байна. Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны "Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай" 05 дугаар тогтоолоор ХАСХОМ-ийн маягт шинэчилсэнтэй холбогдуулан уг мэдүүлгийг нөхөх зааврыг Авлигатай тэмцэх газрын даргын 2024 оны А/96 дугаар тушаалаар баталж, 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан байгууллагын хэмжээнд 2025-01-07-ны өдөр 1 удаа бүх албан хаагчдад сургалт зохион байгуулав. Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтсээс 2025-01-06-ны өдөр зохион байгуулсан сургалтад хамрагдаж, ХАСУМ, ХАСХОМ Мэдүүлэг тайлбар гаргахтай холбоотой мэдээллийг байгууллагын хэмжээнд хүргэж, дотоод сургалтыг 1 удаа зохион байгуулав.		
Хэсгийн дундаж: 100%						

Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол

1	"Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд авах арга хэмжээний тухай", 2025-06-10	1.3.1	-	Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд арга хэмжээ авах үүднээс байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2025 онд ажиллах төлөвлөгөөг боловсруулж, албан хаагчдыг Ёс зүйн хороо болон бусад байгууллагаас зохион байгуулж байгаа ёс зүйн сэдэвт сургалтад хамруулж, дэд хороо нь төлөвлөгөөнд заасны дагуу сургалт болон сурталчлан таниулах ажлууд хийгдсэн.	100%	-	-
2	"Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн "Алсын хараа-2050", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын баримт бичигт туссан үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор геологи, хайгуулын салбарт шинэчлэл хийх хүрээнд дараах арга хэмжээг авч	1-7	Геологи хайгуулын салбарт шинэчлэлт хийх	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт ҮГА-аас төлөөлөл оролцож, хуулийн төслийн үзэл баримтлал, нэмэлт өөрчлөлтийн төслийг бэлтгэж Сангийн яамнаас санал авахаар хүргүүлсэн. Мөн чухал ашигт малтмалын нэр төрлийг тодорхойлох, чухал ашигт малтмалын жагсаалтын төслийг боловсруулах, холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах саналын төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Геологийн судалгаатай хамааралтай үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн хуулийн этгээдүүдийг нэгтгэх, байгууллагуудын чиг үүргийн давхардлыг багасгах, уялдаа холбоог сайжруулах, хамаарал бүхий үйл ажиллагааг Монгол орны эрдэс баялгийн тархалт, хэтийн төлөв, түүний ашиглалт, судалгааны нэгдмэл мэдээллийн суурь баазыг бий болгох	100%	-	-

	хэрэгжүүлэх тухай", 2025-07-09			чиглэсэн үйл ажиллагаанд шууд татан оролцуулах эрх зүйн боломжит хувилбаруудын талаар мэдээллийг бэлтгэж АҮЭБЯ-нд танилцуулсан. Мөн ЗГ-ын хуралдаанд шаардлагатай мэдээллүүд, шийдвэрийн төслийг бэлтгэж 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар орохоор хүлээгдэж байна.			
Хэсгийн дундаж: 100%							
Засгийн газрын тогтоол							
1	"Олон улсын худалдааны тарифын нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай", 2025-03-12	1	1. Олон улсад үүсэж байгаа геополитикийн болон худалдааны хурцадмал, тодорхойгүй нөхцөл байдалтай холбогдуулан хүн амд үзүүлэх үйлчилгээний зохицуулалтын уялдааг хангах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчны тогтвортой байдлыг дэмжих зорилгоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний төлбөр, хураамжийг 2025 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар, зөвлөл, хороо, комиссын дарга нар, бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгож, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоодог бүх төрлийн татвар, хураамжийн хувь, хэмжээг	Архивын ерөнхий газрын даргын "Төрийн архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ"-г шинэчлэн тогтоох 2023.08.24-ний А/68 дугаартай тушаалын 2-р хавсралтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%	-	-

			нэмэгдүүлэхгүй байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.				
2	"Ураны хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд иргэдийн хяналт, оролцоог хангах зарим арга хэмжээний тухай", 2025-05-07	1.1	1.1. Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт хийгдсэн ураны геологи, хайгуулын ажлын үр дүн болон уран олборлолтын техник, технологийн орчин үеийн шийдэл, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг бэлтгэн, олон нийтэд хүргэх арга хэмжээ авахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Ашигт малтмал, газрын тосны газар (Ш.Ганхуяг), Үндэсний геологийн алба (П.Батцацрал)	АҮЭБЯ-ны Эрдэс баялгийн бодлогын газарт 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр уг тогтоолын 1.1 дэх заалтын дагуу холбогдох мэдээллийг бэлтгэн боловсруулж, түүнийг олон нийтэд хүргэх боломжтой эсэх талаар чиглэл хүссэн 1/377 тоот албан бичгийг хавсралтын хамт хүргүүлсэн.	100%	-	-
3	"Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, гадаад валютын улсын нөөцийг өсгөх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 2025-03-19	4.1	4.1. Алтны олборлолтыг нэмэгдүүлэх, "Алт-3" аяныг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваанд, энэ чиглэлээр хамтран ажиллахыг Монгол банкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд:	Ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгдсэн эрх зүйн хувьд хориглосон, хязгаарласан нутаг дэвсгэртэй давхцалтай алтны үндсэн ордын бүртгэгдсэн нөөц, тэдгээрийн тусгай зөвшөөрлийн мэдээллийг бэлтгэж 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 1/296 албан бичгээр АҮЭБЯ-д хүргүүлсэн.	100%	-	-
Хэсгийн дундаж: 100%							
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл							
1	"Монгол Улсад 2025 онд зохион байгуулах аялал жуулчлалын нэгдсэн	2	2. Цаашид жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө дараа жилд зохион байгуулах аялал жуулчлалын арга хэмжээний саналаа	Монгол Улсад 2025 онд байгуулах аялал жуулчлалын нэгдсэн цагалбарт тусгагдсан ажлуудаас 9-сарын 11-13 нд зохион байгуулагдсан Уул уурхайн 7 хоногт ҮГА- амжилттай оролцсон.	100%	-	-

	цаглабарын талаар", 2025-01-08		аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, нэгдсэн цаглабарын дагуу хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус үүрэг болгов.	Хурлын үеэр тус албанаас 3 илтгэл хэлэлцүүлж, мөн албаны дарга Н.Мөнхбилэг болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Геологийн албаны дэд ерөнхийлөгч Сю Сюэ И нар "Mining Week & Mine Pro-2025" олон улсын үзэсгэлэн, чуулга уулзалтын үеэр хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан. Энэхүү ёслолын ажиллагаанд Монгол талын төлөөлөгчдөөс гадна БНХАУ-ын талаас Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шэнь Миньжуан, Хятадын Геологийн албаны дэд ерөнхийлөгч Сю Сюэ И, Хятадын Геологийн албаны Шинжлэх ухаан, технологи болон олон улсын хамтын ажиллагааны газрын дэд захирал Жэн Сюнвэй, Хятадын Геологийн албаны Шинжлэх ухаан, технологи болон олон улсын хамтын ажиллагааны газрын Олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ли Вэй, Хятадын Геологийн албаны Шэньян төвийн захирал Жиа Вэйгуан, Хятадын Геологийн албаны Шэньян төвийн Хойд Зүүн Азийн хэлтсийн дарга Жоу Юнхэн, Хятадын Геологийн албаны Шэньян төвийн Хойд Зүүн Азийн хэлтсийн төслийн удирдагч У Таотао зэрэг албаны хүмүүс оролцсон.			
2	"Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр-III"-ийн хэрэгжилт, төрийн албан	2	Үүнтэй холбогдуулан Монгол хэлний тухай хуулийн 7.2-т заасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төрийн болон нутгийн	Уг аяны хүрээнд 2024 онд Чой Лувсанжавын нэрэмжит Хэл шинжлэлийн хүрээлэнтэй гэрээ байгуулж байгууллагын 30 албан хаагчийг монгол бичгийн анхан	100%	-	-

	хэргийг хос бичгээр хөтлөх зөвлөмжийн талаар" 2025.01.14		өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах болсон тул уг асуудлаар холбогдох байгууллагуудад "Зөвлөмж" хүргүүлж, хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Боловсролын сайд П.Наранбаярт, зөвлөмжийн дагуу зохих арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгов." гэжээ.	шатны сургалтад хамруулж, 2025 онд дунд шатны сургалтад 26 албан хаагч хамрагдаж гэрчилгээ олгосон, албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах бэлтгэл ажлыг хангаж хэрэгжүүлж эхэлсэн.			
3	"Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, үнэлгээг ил тод, нээлттэй мэдээлэхтэй холбоотой авах зарим арга хэмжээний талаар", 2025-08-06	1	1.Төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн 2024 он болон 2025 оны эхний хагас жилийн тайлан, үнэлгээг байгууллагын цахим хуудсанд 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор байршуулан олон нийтэд ил тод, нээлттэй болгохыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн төрийн захиргааны бүх шатны байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгаж, Улсын Их Хурлын Тамгын газар, түүний харьяа байгууллагын удирдлагад тус тус зөвлөв.	"Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, үнэлгээг ил тод, нээлттэй мэдээлэхтэй холбоотой авах зарим арга хэмжээний талаар" 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлийг үндэслэн МУЗГХЭГ-ын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн ХЭГ/2129 дугаартай албан бичгийн дагуу хэрэгжилтийг ханган 8 дугаар сарын 20-ны дотор ЗГХЭГ-т 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн Цахим хуудсанд мэдээлэл байршуулж 1/608 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн.	100%	-	-
4	Иргэдээс төрийн захиргааны төв	3	3.Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал,	2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар байгууллагын	100%	-	-

	болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2025 оны эхний хагас жилийн тайлангийн талаар" 2025-09-10		шийдвэрлэлтийг нэгдсэн мэдээллийн санд тухай бүр бүртгүүлж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт." гэжээ.	хэмжээнд Иргэд, ААН-ээс байгууллагын удирдлага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл гомдол 31 ирснээс 100% шийдвэрлэгдсэн заасан хугацаанд цахим системд бүртгүүлж ажиллаж байна.			
5	"Төсвийн зарцуулалт, сахилга батын тухай" 2025-09-24	3	3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд ил тод, нээлттэй байхаар заасныг болон Төрийн болон албаны нууцын тухай хууль, журмыг зөрчин үндэслэлгүйгээр нууцалсан мэдээллийг ил болгох ажлыг шуурхай зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, тэдгээрт харьяалагдах төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт, хэрэгжилтад хяналт тавьж, дүнг 2025 оны 10 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т."	"Төсвийн зарцуулалт, сахилга батын тухай" 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Тагнуулын ерөнхий газрын 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн ТЕГ01/409 дугаартай Хууль тогтоомжийн биелэлтийг хангаж, хамтран ажиллах тухай албан бичгийн дагуу АҮЭБЯ-нд 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 1/718 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ханган ажилласан.	100%	-	-

6	"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүнгийн талаар", 2025-09-24	1	1. Хяналт-шинжилгээний тайлангийн дүнгийн мөрөөр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.	Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг эхний хагас жилээр гаргаж АҮЭБЯ-нд 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 1/467 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүнгийн талаар" 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд ҮГА-ны даргын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/56 дугаартай тушаалаар байгуулсан. 2025 онд албанд ирсэн УИХ, Ерөнхийлөгч, ҮАБЗ болон Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд судалгаа хийж 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд дотоод хяналт хийсэн тухай танилцуулга, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг III улирлын байдлаар нэгтгэн тайлагнаж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 1/835 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Үндэсний геологийн албаны хариуцан гүйцэтгэхээр тусгасан "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын засгийн	100%	-	-
---	--	---	---	--	------	---	---

				газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 1/903 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.			
7	Монгол Улсын Засгийн газрын 20 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-10-08	1, 2, 3	1.эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн төрөлжсөн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг "Төрийн мета-өгөгдлийн нэгдсэн сан"-д бүртгүүлэх; 2. төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем болон мэдээллийн санг цахим систем (system.gov.mn)-д бүртгүүлэх; 3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр үзүүлэх." гэжээ	1. Үндэсний статистикийн хорооноос нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу хөгжүүлсэн төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан https://metadata.nso.mn -д сайтад хариуцаж буй өгөгдлийн сангийн мета өгөгдлийг оруулах албан бичгийн хүрээнд тухайн сайтад нэвтрэх эрх үүсгүүлэн мета өгөгдөл оруулахад бэлэн болсон. Nso.mn (Үндэсний статистикийн хороо)-ноос мета өгөгдөл оруулах ажлын хүрээнд webgis.mris.mn сайтын мета өгөгдлийг бэлдэж үндэсний статистикийн хорооны мэргэжилтэн Н.Дэлгэрнаран руу илгээсэн. 2. system.gov.mn дээр байгууллагын эрх үүсгүүлж холбогдох мэдээллийг ЦХХХЯ-наас авсан. 3. 2025 оны 11 дүгээр сарын 04-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын "Албан бус эдийн засгийг албажуулах төсөл", "И-Монгол академи" УТҮГ нарын хамтран зохион байгуулсан "Төрийн үйлчилгээг цахимжуулах "E-Business 2.0" төрийн	100%	-	-

				байгууллагуудын зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэгт” ГМТ-н ажилтан Ч.Тэмүүжин, ТЗУХ-н ажилтан Г.Золжаргал нар оролцсон. Хэлэлцүүлэгт тус албаны үзүүлдэг үйлчилгээний нэг болох Хилээр дээж /сорьц/ нэвтрүүлэх тодорхойлолт олгох үйлчилгээг цахимжуулах шаардлагатай байгааг танилцуулсан. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт манай албаны үзүүлдэг Хилээр дээж /сорьц/ нэвтрүүлэх тодорхойлолт олгох, нөөцийн бүртгэл болон орд илэрлийн давхцлын лавлагаа олгох үйлчилгээнүүдийг цахимжуулах хүсэлтээ 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 1/834 тоот албан бичиг хүргүүлсэн.			
8	Монгол Улсын Засгийн газрын 26 дугаар хуралдааны тэмдэглэл, 2025-11-05	4	4.Иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх ажлын хүрээнд яам, Засгийн газрын агентлагууд иргэдийг хүлээн авч уулздаг өдөр, хуваарийг гарган мөрдүүлж иргэдээс тавьсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, үйлчилгээний соёл, чанарыг төлөвшүүлэх арга хэмжээг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов;	4. Иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх ажлын хүрээнд албаны даргын 2025 оны 11 сарын 24-ний А/59 дугаартай тушаалаар иргэдийг хүлээн авч уулздаг өдөр, хуваарийг баталж мөрдүүлэн иргэдээс тавьсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, үйлчилгээний соёл, чанарыг төлөвшүүлэн ажиллаж байна.	100%	-	-
Хэсгийн дундаж: 100%							
Ерөнхий сайдын албан даалгавар							

1	Монгол Улсын Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгавар "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай", 2025-06-18	1, 2, 3	1. Засгийн газрын үйл ажиллагаа шуурхай, тасралтгүй, тогтвортой байх зарчмыг хангаж ажиллах хүрээнд: 2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр: 3. Засгийн газрын хуралдааны дэг, зохион байгуулалтыг хангах чиглэлээр:	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай" – АҮЭБЯ-нд сар бүрийн 25-ны өдрийн дотор хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна. АҮЭБЯ-нд албан даалгаврын хэрэгжилтийг 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдөр цахимаар, 2025 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн 1/672 дугаар албан бичгээр, 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 1/753 дугаар албан бичгээр. 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1/826 дугаар албан бичгээр тус хүргүүлж 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажилласан.	100%	-	-
2	Монгол Улсын Ерөнхий сайдын 04 дүгээр албан даалгавар "Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2025-07-25	1.2, 1.3, 1.4, 1.7,	1.2. төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж	1.2 Тус албан даалгаврын дагуу Үндэсний геологийн албаны хэмжээнд чөлөөлөгдсөн албан хаагчийн орон тоо, сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийгдээгүй болно. Мөн түүнчлэн Засгийн газрын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ний өдрийн "Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Үндэсний геологийн албаны орон тооны дээд хязгаарыг 32 байхаар 9 хувь бууруулж тогтоосон. 1.3, 1.4 Үндэсний геологийн албаны даргын 2025 оны 8 дугаар сарын 02-ны А/44 тушаалаар Ёс зүйн дэд хороог байгуулан ажиллаж байгаа ба тус	100%	-	-

			ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад, 1.3. иргэддээ чин шударгаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад, 1.4.төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцээн байгуулж ажиллуулахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагад, 1.7. Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх	хорооноос Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах зорилгоор 2025 оны 10 дугаар сард албан хаагчдад ёс зүйн сургалтыг зохион байгуулсан. Мөн шинэчлэн боловсруулсан Албан тушаалын тодорхойлолтын төсөлд тус хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тусгасан. 1.7 Тус албан даалгаврын дагуу хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчийг төрийн албанаас чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргаагүй болно. Харин 1.2-т дурдсан Засгийн газрын тогтоол болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/169 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан Үндэсний геологийн албаны бүтцийн ерөнхий бүдүүвч, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн хүрээнд байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн баталж, холбогдох төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, хянуулахаар АҮЭБЯ-ны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлд илгээгээд байна.			
--	--	--	--	--	--	--	--

			шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт;				
Хэсгийн дундаж: 100 хувь							
Нийт дундаж: 100 хувь							

ТАНИЛЦСАН:

Үндэсний геологийн албаны даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

(албан тушаал)


(гарын үсэг)


/Н.МӨНХБИЛЭГ/

2025-12-19 (огноо)

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:

Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн дарга

(албан тушаал)


(гарын үсэг)

/С.ШИНЭ-ОД/

2025-12-19 (огноо)

ХЭРЭГЖИЛТ ТАЙЛАГНАСАН:

Хууль, эрх зүйн асуудал хариуцсан
мэргэжилтэн

(албан тушаал)


(гарын үсэг)

/Т.ШИХИХУТАГ/

2025-12-19 (огноо)